350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	93,599,500.00	32,281,221.85
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	100,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	460,148,700.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	400,280,009.90
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	373,989,054.94
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>165.00</b>	<b>129.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>5.00</b>	<b>5.00</b>
610001	Төсвийн байгууллага	5.00	5.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>80.00</b>	<b>62.00</b>
620001	Удирдах ажилтан	12.00	12.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	56.00	38.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>310,249,600.00</b>	<b>94,897,852.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>310,249,600.00</b>	<b>94,897,852.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>241,746,860.00</b>	<b>38,903,648.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>103,589,950.00</b>	
210101	Үндсэн цалин	103,589,950.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,185,350.00</b>	
210201	Тэтгэврийн даатгал	16,185,350.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,535,000.00</b>	
210401	Бичиг хэрэг	1,535,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>56,392,930.00</b>	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,489,350.00	
210502	Хоол, хүнс	5,903,580.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>300,000.00</b>	
210604	Урсгал засвар	300,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,302,970.00</b>	<b>14,092,296.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,302,970.00	14,092,296.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>41,440,660.00</b>	<b>24,811,352.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,440,660.00	24,811,352.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,502,730.00</b>	<b>55,994,204.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>41,900,000.00</b>	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,900,000.00	
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>26,602,730.00</b>	<b>55,994,204.20</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		12,702,084.96
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	26,602,730.00	43,292,119.24
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>322,951,680.00</b>	<b>82,195,767.24</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>322,951,680.00</b>	<b>82,195,767.24</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,662,000.00	15,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,748,690.00	28,600,803.24
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	243,578,760.00	13,064,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,962,240.00	25,530,164.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>12,702,080.00</b>	<b>-12,702,084.96</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		12,702,084.96
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>12,702,080.00</b>	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг дарга нь “Бид төрийн албыг мэргэшсэн боловсон хүчин тэдний өөдрөг хүсэл тэмүүлэл дээр тулгуурлан монгол улсынхаа хөгжил дэвшилд манлайлан оролцож Төрийн захиргааны байгууллагын стандарт манлайллыг хангаж, судалгаанд суурилсан үр дүнд чиглэсэн шуурхай, хүртээмжтэй үйлчилгээг иргэдэд хүргэх” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,083.5 сая төгрөгөөр буюу 56.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	520.5	434.0	-86.5
Авлага	374.3	428.9	54.6
Бараа материал	283.5	118.6	-164.9
Үндсэн хөрөнгө	4,264.7	2,102.0	-2,162.7
Нийт хөрөнгө	5,443.0	3,083.5	-2,359.5

<b>Өр төлбөр</b>	124.1	296.2	172.1
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	5,318.9	2,787.3	-2,531.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,443.0</b>	<b>3,083.5</b>	<b>-2,359.5</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 86.5 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн ерөнхий орлогод татварын орлого тасарсан, орон нутгийн хөгжлийн сангаас төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн нь нөлөөлсөн байна.
- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 54.6 сая төгрөгөөр өссөн нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн бараа материал бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлсэн, мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 32.3 сая төгрөгөөр буурч, малын тоо толгойн албан татвар 146.5 сая төгрөгийг авлагаар тусгасан нь нөлөөлсөн байна.
- Бараа материал, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид санхүүгийн тайланг нэгтгүүлсэн нь нөлөөлсөн байна.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

#### **3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 434.0 сая төгрөг болж, өмнөх оноос 86.5 сая төгрөгөөр буурсан байна.

#### *Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	520.5	434.0	-86.5
Төгрөг	520.5	434.0	-86.5
Төрийн сангийн харилцах	500.4	425.1	-75.3
Арилжааны банк дахь харилцах	7.4	8.9	1.5
Нэмэлт санхүүжилтийн харилцах	12.7	-	-12.7
<b>Дүн</b>	<b>520.5</b>	<b>434.0</b>	<b>-86.5</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 425.1 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 8.9 сая төгрөг байгууллагын арилжааны банкны харилцах дансанд байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийн 118.5 сая төгрөг буюу 27.8 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 255.5 сая төгрөг буюу 60.1 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 51.1 сая төгрөг буюу 12.1 хувь төрийн сангийн харилцахын оны эхний зарцуулагдаагүй үлдэгдэл тус тус эзэлж байна.

#### **Аудитын илрүүлэлт**

- Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал 163.8 мянган төгрөгийг олгосон. /Чоногол хөгжил ОНӨААТҮГ/
- Төлбөр тооцооны баримтад 32.3 сая төгрөгийн баримт илүү, дутуу бүртгэсэн байна./ЗДТГ/
- Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, сур харвааны талбайн тохижилтын ажлуудтай холбоотой 8 төсөл арга хэмжээг 20.0 сая төгрөгөөс хэтрээгүй гэх үндэслэлээр 150.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан, жижиглэн хувааж тендер зарлаагүй./ОНХС/
- Бэлчээрийн усан хангамж сайжруулах хөдөөгийн 2 багт худаг гаргах ажлын захиалагчийн хяналт, зохиогчийн хяналт, магадлашгүй ажил хийгдээгүй байхад гүйцэтгэгч компанид 1.5 сая төгрөг санхүүжилт илүү олгогдсон./ОНХС/
- Баяр наадмын талбай шинээр барих ажлын захиалагчийн хяналт хийгдээгүй байхад гүйцэтгэгч компанид 4.8 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон./ОНХС/

- Гудамж талбайд гэрэлтүүлэг хийх ажил, Үндэсний бөхийн хэрэгсэл, Сумын төвийн замын тэмдэг тэмдэглэлээ хийх, Сурын талбайн дотор тохижуулалт, хэрэгсэл зэрэг ажлуудад санхүүжилт 100 хувь гарсан боловч 37.5 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн, гэрээний хугацаанд хүлээн аваагүй./ОНХС/
- Магадлалаар баталгаажсан зураг төсөлгүй 173.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.
- ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналгүй 330.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн./ОНХС/

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 428.8 сая төгрөг болж, өмнөх оноос 54.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Төлбөртэй үйлчилгээний авлага	89.0	43.2	-45.8	
Зээлийн хүүгийн авлага	8.8	8.8	-	
Байгууллагаас авах авлага	21.8	7.6	-14.2	
Хувь хүмүүсээс авах авлага	-	146.5	146.5	
Зээлийн авлага	254.7	222.4	-32.3	
Урьдчилгаа	-	0.3	0.3	
<b>Дүн</b>	<b>374.3</b>	<b>428.8</b>	<b>54.5</b>	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 231.2 сая төгрөг, малын тоо, толгойн албан татвар 146.5 сая төгрөг байна.

### Аудитын илрүүлэлт

- Нийгмийн даатгалын шимтгэлийг тайланд илүү тайлагнаж 304.8 мянган төгрөгийг зардалд илэрхийлсэн. /Чоногол хөгжил ОНӨААТҮГ/
- Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан иргэд 105.4 зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, барагдуулаагүй. /ХХС/
- Зээлийн барьцааны гэрээг /үл хөдлөх хөрөнгө барьцаалсан тохиолдолд/ хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, баталгаажуулаагүй. /ХХС/

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 118.6 сая төгрөг болж, өмнөх оноос 189.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Түүхий эд материал	32.6	24.4	-8.2	
Тусгай зориулалттай материал	23.7	-	-23.7	
Эм боох материал	8.9	24.4	15.5	
Бэлэн бүтээгдэхүүн	6.9	6.3	-0.6	
Хангамжийн материал	190.9	72.0	-118.9	
Бичиг хэргийн материал	2.7	0.1	-2.6	
Аж ахуйн материал	167.1	56.0	-111.1	
Сэлбэг хэрэгсэл	2.1	15.7	13.6	
Түлш, шатах тослох материал	1.8	0.2	-1.6	
Барилгын засварын материал	0.1	-	-0.1	
Хүнсний материал	1.8	-	-1.8	
Бусад хангамжийн материал	15.3	-	-15.3	
Мал амьтад	53.0	15.9	-37.1	
<b>Дүн</b>	<b>308.4</b>	<b>118.6</b>	<b>-189.8</b>	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 118.6 сая төгрөгийн үлдэгдлийн 13.4 хувийг мал амьтад, 60.7 хувийг хангамжийн материал, 20.5 хувийг эм боох материал эзэлж байна. Хангамжийн материалд аж ахуйн материалын үлдэгдэл гол нөлөөлж байна. Аж ахуйн материалын

91.1 хувийг Засаг даргын Тамгын газар, 2.3 хувийг иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 6.4 хувийг ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд эзэлж байна.

### Аудитын илрүүлэлт

- Тээвэр шатахууны 5.7 сая төгрөгийн зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох арга зүй, стандартын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй. /Чоногол хөгжил ОНӨААТҮГ/
- Эдийн засгийн ангиллаар бараа материалын дансанд буруу бүртгэгдсэн 8 ширхэг 35.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. /ЗДТГ/

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,112.5 сая төгрөг болж, өмнөх оноос 2,203.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>4,213.3</b>	<b>2,091.5</b>	<b>(2,121.8)</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,720.6	1,538.4	(2,182.2)
39202	Хуримтлагдсан элэгдэл	(533.2)	(312.5)	220.8
39203	Авто-тээврийн хэрэгсэл	528.1	334.4	(193.7)
39204	Хуримтлагдсан элэгдэл	(272.1)	(236.1)	36.0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	764.8	356.3	(408.5)
39206	Хуримтлагдсан элэгдэл	(531.6)	(199.4)	332.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	363.6	64.0	(299.6)
39208	Хуримтлагдсан элэгдэл	(260.1)	(37.2)	223.0
39209	Зам, гүүрийн байгууламж	39.5	39.5	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7.9)	(11.8)	(3.9)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	47.4	-	(47.4)
39214	Бусад үндсэн хөрөнгө	447.0	635.4	188.4
39215	Хуримтлагдсан элэгдэл	(112.8)	(79.5)	33.2
39217	Ном	20.1	-	(20.1)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>51.3</b>	<b>10.5</b>	<b>(40.8)</b>
39301	Програм хангамж	3.1	1.4	(1.7)
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2.1)	(0.4)	1.7
39303	Бусад биет бус хөрөнгө	50.3	9.5	(40.8)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,316.0</b>	<b>2,112.5</b>	<b>(2,203.5)</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 32.2 сая, бусад 932.8 сая нийт 965.0 сая төгрөгөөр нэмэгдэж, Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид нэгтгүүлсэн 3,970.6 сая төгрөг, нийт 2,203.5 сая төгрөгөөр буурсан байна.

### Аудитын илрүүлэлт

- Тооллогын комисс томилсон ч эд хөрөнгө нэг бүрийг үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж, баталгаажуулаагүй зөрчил илэрлээ . /Чоногол хөгжил ОНӨААТҮГ/
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 79 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. /ЗДТГ/
- Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг анхан шатны баримтаас зөрүүтэй тайлагнасан. /ЗДТГ/

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр тайлант онд 235.0 сая төгрөг болж, 174.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бүүрэлт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1.9	1.9	-
Байгууллагад төлөх өглөг	55.9	226.9	171.0
Хувь хүмүүст төлөх өглөг	1.1	1.1	-
Татварын өглөг /ТӨҮГ/	1.2	5.1	3.9
Дансны өглөг /ТӨҮГ/	0.7	-	-0.7
Дүн	60.8	235.0	174.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагад төлөх өглөгийн 216.4 сая төгрөг нь төсөл арга хэмжээний дутуу санхүүжилт, 8.7 сая төгрөг нь Чоногол хөгжил ОНӨААТҮГ, 1.7 сая төгрөг ЗДТГ-ын өр төлбөр байна..

### Аудитын илрүүлэлт

- Нийгмийн даатгалын шитгэлийн тайланд цалингийн зардлыг дутуу тайлагнасан. /ЗДТГ/

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,787.4 сая төгрөг болж, өмнөх оноос 2,531.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бүүрэлт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,641.3	276.5	-2,364.8
Өмч /төрийн/	2,641.3	276.5	-2,364.8
Хуримтлагдсан үр дүн	978.7	2,105.4	1,126.7
Өмнөх үеийн үр дүн	897.3	4,573.2	3,675.9
Тайлант үеийн үр дүн	81.4	-2,467.8	-2,386.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,698.8	405.5	-1,293.3
Дүн	5,318.8	2,787.4	-2,531.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн дүн 2,787.4 сая төгрөг болж 2,531.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагч нэгтгэл хийгдсэнээс засгийн газрын оруулсан капитал 2,364.8 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 1,293.3 сая төгрөгөөр буурч, хуримтлагдсан үр дүн 1,126.7 сая төгрөгөөр нэмэгдэж тайлант үед 2,386.4 сая төгрөгийн үр дүнгүй ажилласан нь нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн 04 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлого 930.1 сая төгрөг, татварын бус орлого 176.7 сая нийт 689.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 487.8 сая, татварын бус орлого 110.2 сая нийт 1,106.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэл 20.0 хувиар тасарсан байна.

Хүснэгт 10 Орлогын биелэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өссөн /Буурсан/
НИЙТ ОРЛОГО	1,106.8	885.7	-221.2
ТАТВАРЫН ОРЛОГО	930.1	852.8	-77.3
Хувь хүний орлогын албан татвар	548.0	594.7	46.7

Цалин, хөдөлмөрийн хөлс,шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татвар	450.0	515.0	65.0
Үйл ажиллагааны орлого	25.0	22.8	-2.2
Хөрөнгийн орлого	55.0	44.8	-10.2
Шууд бус орлого	10.0	12.1	2.1
Хөрөнгө борлуулсны орлого	8.0	-	-8.0
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>286.6</b>	<b>163.2</b>	<b>-123.4</b>
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	21.5	21.5
Бууны албан татвар	2.5	2.7	0.2
Малд ногдуулах албан татвар	284.1	139.0	-145.1
<b>Бусад татвар (төлбөр, хураамж)</b>	<b>95.5</b>	<b>95.0</b>	<b>-0.5</b>
Улсын тэмдэгтийн хураамж	5.0	4.2	-0.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5.0	0.8	-4.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	25.0	-	-25.0
Ус рашаан, ашигласны төлбөр	7.0	12.5	5.5
Газрын төлбөр	<b>28.5</b>	<b>33.4</b>	<b>4.9</b>
Газрын төлбөр	28.5	33.4	4.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	<b>32.0</b>	<b>56.6</b>	<b>24.6</b>
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	7.0	12.5	5.5
Байгалийн ургамалын нөөц ашигласны төлбөр	25.0	44.1	19.1
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>176.7</b>	<b>32.8</b>	<b>-143.9</b>
Хүү, торгуулийн орлого	35.0	22.8	-12.2
Нэр заагдаагүй орлого	141.7	10.0	-131.7

Орон нутгийн татварын болон татварын бус орлого нийт дүнгээрээ төлөвлөснөөс 221.2 сая төгрөгөөр тасарсан байна. Малын тоо толгойн татвар 145.1 сая төгрөг, нэр заагдаагүй татвар 131.7 сая төгрөгөөр тасарсан нь нөлөөлсөн байна. Цалин түүнтэй адилтгах орлого 65.0 сая төгрөгөөр давсан нь Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

### Аудитын илрүүлэлт

- Малын тоо толгойн албан татвар 145.1 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн /Засаг дарга/

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,041.1 сая төгрөг, нийт зардлыг 3,041.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын 2022 оны төсөвт тусгай зориулалтын байгууллагын тогтмол зардал 268.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,309.5 төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 3,309.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,301.5 сая төгрөгийг урсгал зардалд, 1,828.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 179.7 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,341.3 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 1,133.0 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 32.4 сая нийт 2,506.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,526.9 сая төгрөг буюу 76.3 хувьтай байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
<b>70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага</b>					

1	80101-Үндсэн үйл ажиллагаа	122.1	101.36	20.74	83%
2	80224- Зөвлөл, хороо, комиссын гишүүд	14.58	14.58	0	100%
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1.50	1.48	0.02	99%
4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	12.40	11.20	1.2	90%
5	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	16.00	16.00	0	100%
6	82706-Гоц халдварт өвчний голомтыг арилгах	1.70	0	1.7	0%
<b>Дүн</b>		<b>168.28</b>	<b>144.62</b>	<b>23.66</b>	
<b>70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	347.80	338.40	9.4	97%
2	80106- Баг хорооны үндсэн үйл ажиллагаа	150.30	144.66	5.64	96%
3	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	6.90	6.91	-0.01	100%
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	7.65	7.50	0.15	98%
5	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	60.00	59.42	0.58	99%
6	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	30.00	29.97	0.03	100%
7	81549- Ахмадын сан	2.10	2.10	0	100%
8	82706-Гоц халдварт өвчний голомтыг арилгах	20.00	20.00	0	100%
9	82212-Хур хог хаягдал, орчны бохирдл	8.30	7.33	1.0	88%
10	81701-Байгаль хамгаалах ,нөхөн сэргээх зардал	10.00	10.00	0	100%
11	83201- Ангилалдаагүй бусад зардал	5.90	5.90	0	100%
<b>Дүн</b>		<b>648.95</b>	<b>632.19</b>	<b>16.76</b>	
<b>71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	42.21	35.33	6.88	84%
2	83201- Ангилалдаагүй бусад зардал	5.29	4.5	0.8	85%
<b>Дүн</b>		<b>47.50</b>	<b>39.82</b>	<b>7.68</b>	
<b>71802 ерөнхий боловсрол</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	167.59	162.79	4.8	97%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	60.11	60.11	0	100%
<b>Дүн</b>		<b>227.70</b>	<b>222.90</b>	<b>4.8</b>	
<b>71801 сургуулийн өмнөх боловсрол</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	71.28	68.66	2.62	96.32%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	43.39	43.39	0	100.00%
3	83201- Ангилалдаагүй бусад зардал	23.80	23.80	0	100%
<b>Дүн</b>		<b>138.47</b>	<b>135.85</b>	<b>2.62</b>	
<b>71702 соёл урлаг</b>					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	61.20	61.02	0.18	99.71%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	4.88	4.88	0	100.00%
2	83201- Ангилалдаагүй бусад зардал	4.50	4.49	0	100.00%
<b>Дүн</b>		<b>70.58</b>	<b>70.39</b>	<b>0.19</b>	
<b>Орон нутгийн хөгжлийн сан хөтөлбөр бичих</b>					
2	83401-Итгэлцүүрээр	1108.64	804.83	303.81	72.60%
3	80918- Бусад	373.95	306.87	67.08	82.06%
4	83405-Малын тоо толгойн албан татвар	284.09	89.50	194.59	31.50%
5	83406-ОНХС-бусад	61.55	80.00	-18.45	129.98%
<b>Дүн</b>		<b>1828.23</b>	<b>1281.20</b>	<b>547.03</b>	
<b>72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих</b>					
1	82611-Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих				
2	83111-Сум хөгжүүлэх	179.79	0	179.79	0.00%
<b>Дүн</b>		<b>179.79</b>	<b>0</b>	<b>179.79</b>	<b>0.00%</b>
<b>Нийт дүн</b>		<b>3,309.50</b>	<b>2,526.97</b>	<b>782.53</b>	

Орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой орон нутгийн хөгжлийн санд тусгасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлууд дутуу санхүүжигдсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 15.0 сая, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 28.6 сая, дээд шатны төсвийн захирагчаас 13.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25.5 сая нийт 82.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 14.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 24.8 сая, нийт 38.9 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 56.0 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2023 оны 3 дугаар сарын 15 -аас 2023 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 01/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 3,039.1 сая төгрөгийн зардлын 1.5 хувь буюу 31.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрдэнэцагаан сумын Засаг даргын тухай хуульд хамаарах зүйл заалт бүрээр горим сорил хэрэгжүүлсэн.

#### Аудитын илрүүлэлт

- Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс 2.7 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн. /ИТХ/

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүйд 1 албан тушаалтанд хариуцлага тооцохоор, 3 байгууллагад алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	62.2	1	27.2	1	35.0	43.7
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100
Зөвлөмж	1	-	1	-	-	-	100
Нийт	3	62.2	3	27.2	1	35.0	

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 145.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **Орлоготой холбоотой асуудал**

###### 5.3.1 Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татвар 145.1 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно./, 6 дугаар зүйлийн 6.2 /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, Төсвийн

тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
/сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	6	68.7	-	-	-	-	5	68.7	1	1		
Хоршоо хөгжүүлэх сан	3	105.5	-	-	1	92.1	2	13.4				
Орон нутгийн хөгжлийн сан	8	699.4	3	8.2	5	691.2						
Чоногол хөгжил ОНӨААТҮГ	4	6.2	2	0.5	1	-	1	5.7				
<b>Дүн</b>	<b>21</b>	<b>879.8</b>	<b>5</b>	<b>8.7</b>	<b>7</b>	<b>783.3</b>	<b>8</b>	<b>87.8</b>	<b>1</b>	<b>1</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал									
/сая төгрөгөөр/									
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	2.7	-	-	-	-	-	1	2.7
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2.7</b>
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	1	-	-	-	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	-	-	-	1	-	-	-	-
Чоногол хөгжил ОНӨААТҮГ	1	-	-	-	1	-	-	-	-
	<b>2</b>	<b>-</b>			<b>3</b>	<b>-</b>			